



ГАЛТ ТЭРЭГНИЙ  
ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН  
НЭГДСЭН ТӨВИЙН ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2024 оны 08 сарын 12 өдөр

Дугаар A/48

Улаанбаатар хот

Г Ёс зүйн дэд хороо шинэчлэн байгуулах тухай

Төрийн албаны ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 6.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол улсын ёс зүйн хорооны 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолын хавсралтаар “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам” шинэчлэн батлагдсантай холбогдуулан төвийн ажилтны хурлын 100 хувийн саналаар төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах хүрээнд ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх чиг үүрэг бүхий Ёс зүйн дэд хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Дэд хорооны  
дарга

Д.Бат-Оргил

Суурь бүтэц, салбар зам хариуцсан  
ахлах мэргэжилтэн

Гишүүд

Д.Өлзийсайхан

Тээврийн нэгдсэн удирдлагын ахлах  
мэргэжилтэн

М.Үүрийнтуяа

Хуулийн мэргэжилтэн

2. Төвийн ажилтны ёс зүйн дүрмийг шинэчлэн батлуулж, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллахыг ёс зүйн дэд хорооны дарга/Д.Бат-Оргил/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан төвийн захирлын 2019 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн “Дүрэм батлах тухай” А/57 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ

А.БУЯННЭМЭХ



161220484